



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2017 ОНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА



АРВАЙХЭЭР
2018 ОН

АГУУЛГА

Оршил.....	10
I. Аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь.....	11
II. Мал аж ахуй.....	12
II.1 Малын бүтээгдэхүүний үйлдвэрлэлт.....	12
II.2 Мал тэжээвэр амьтад, хашаа худгийн 2017 оны тооллогын дүн.....	14
II.3 Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж.....	33
II.4 Тэжээвэр амьтад.....	35
III. Газар тариалан.....	36
Дүгнэлт.....	38
Хавсралтууд.....	39

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт.....	12
Хүснэгт 2. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр.....	13
Хүснэгт 3. Нэг хүнд ногдох мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн.....	13
Хүснэгт 4. Өрх, малчдын тоо, насны бүтэц.....	14
Хүснэгт 5. Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд.....	15
Хүснэгт 6. Малын тоо, төрлөөр.....	17
Хүснэгт 7. Зудны дараах жилийн малын тооны өсөлт, төрлөөр.....	17
Хүснэгт 8. Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд.....	18
Хүснэгт 9. 2001 оноос хойшхи жилүүдийн малын тооны өсөлт, бууралт.....	19
Хүснэгт 10. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь.....	19
Хүснэгт 11. Хувийн малтай өрх, малын тоо.....	21
Хүснэгт 12. Малтай өрхийн малын бүлэглэлт.....	22
Хүснэгт 13. Малтай 1 өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр.....	23
Хүснэгт 14. Хээлтэгч малын тоо.....	23
Хүснэгт 15. Төл бойжилт.....	24
Хүснэгт 16. Бойжуулсан төл.....	25
Хүснэгт 17. 100 эхээс бойжуулсан төл.....	26
Хүснэгт 18. Том малын зүй бусын хорогдол.....	26
Хүснэгт 19. Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь.....	27
Хүснэгт 20. Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо.....	27
Хүснэгт 21. Хээл хаяж, сувайрсан эх малын тоо.....	28
Хүснэгт 22. Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь.....	28
Хүснэгт 23. Хээлтүүлэгч малын тоо.....	29
Хүснэгт 24. Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо.....	29
Хүснэгт 25. Малын хэрэглээний зарлага.....	30
Хүснэгт 26. Зах зээлд худалдаж борлуулсан болон аж ахуйн дотоод хэрэглэсэн малын тоо.....	31
Хүснэгт 27. 2017 оны сүргийн бүтэц.....	31
Хүснэгт 28. Сүргийн бүтэц хувиар.....	32
Хүснэгт 29. Бэлчээрийн хүрэлцээ хангамж.....	33
Хүснэгт 30. Бэлчээрийн тэжээл, нэр төрлөөр.....	34

Хүснэгт 31. Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж.....	35
Хүснэгт 32. Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо.....	36
Хүснэгт 33. Тариалсан талбай, га-аар.....	37
Хүснэгт 34. Хураасан ургац, тн-оор.....	37

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ДНБ-нд ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь.....	11
Зураг 2. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт бууралт.....	12
Зураг 3. Малчдын тоо, насны бүлгээр.....	15
Зураг 4. Малчин өрхийн соёл ахуйн зарим үзүүлэлтүүд.....	16
Зураг 5. Малын тоо, мянган толгойгоор.....	18
Зураг 6. Нийт сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувь.....	20
Зураг 7. Малын тоогоор тэргүүлсэн сумдууд.....	21
Зураг 8. Хээлтэгч малын тооны өсөлт бууралт.....	24
Зураг 9. Бойжуулсан төлийн тоо.....	25
Зураг 10. 100 эхээс бойжуулсан төлийн тоо.....	25
Зураг 11. Том малын зүй бусын хорогдол.....	26
Зураг 12. Хээл хаялт, сувайралт.....	28
Зураг 13. Малын хэрэглээний зарлага.....	30
Зураг 14. Сүргийн бүтэц, хувиар.....	32
Зураг 15. 100 га хадпан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо.....	33
Зураг 16. Бэлтгэсэн хадпан, тн-оор.....	35

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1	Малтай өрх, малчин өрхийн тоо.....	41
2	Малчдын тоо, нас хүйсний бүрэлдэхүүн.....	42
3	Малчдын соёл, ахуйн нөхцөл.....	43
4	Малтай өрхийн малын бүлэглэлт.....	45
5	2017 онд малынхаа тоогоор эхний 5 байрт орсон сум, багууд.....	47
6	2017 оны эцэст байгаа нийт малын тоо.....	48
7	2017 оны эцэст байгаа малын тооны өсөлт, бууралт.....	49
8	Нийт малын тооны өсөлт, бууралт.....	51
9	Малтай нэг өрхөд ногдох амины малын тоо	52

10	2017 оны эцэст байгаа амины малын тоо	53
11	2017 оны эцэст байгаа амины малын өсөлт, бууралт.....	54
12	Нийт сүргийн бүтэц.....	55
13	Тэмээн сүргийн бүтэц.....	56
14	Адуун сүргийн бүтэц.....	57
15	Үхэр сүргийн бүтэц.....	58
16	Хонин сүргийн бүтэц.....	59
17	Ямаан сүргийн бүтэц.....	60
18	Хонин толгойд шилжүүлсэн малын тоо.....	61
19	2017 оны эцэст байгаа хээлтэгч мал.....	62
20	Хээлтэгч малын өсөлт, бууралт.....	63
21	Нийт сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь.....	65
22	Нийт бойжуулсан төл.....	66
23	100 эхээс бойжуулсан төл.....	68
24	Том малын зүй бусын хорогдол.....	69
25	Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо.....	71
26	Хээл хаясан хээлтэгч.....	73
27	Сувайрсан хээлтэгч.....	75
28	Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.....	77
29	Малын хэрэглээний зарлага.....	78
30	Зах зээлд худалдаж борлуулсан, аж ахуйн дотоодод хэрэглэсэн мал...80	
31	Сарлагийн тоо.....	81
32	Бэлчээрийн хүрэлцээ хангамж.....	82
33	Бэлтгэсэн өвс.....	83
34	Гар тэжээл	84
35	Гахай, шувууны тоо.....	85
36	Үндсэн эх, өндөглөгчийн тоо.....	86
37	Малжуулалтын тайлан.....	87
38	2017 онд шинээр гаргасан худгийн тайлан.....	88
39	2017 онд засварласан худгийн тайлан.....	89
40	ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ.....	90

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 Адуу, үхэр - 1 бод.

1 тэмээ - 1.5 бод.

6 хонь - 1 бод.

8 ямаа - 1 бод.

Бог малд хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь

1 адуу - 7 хонь

1 үхэр - 6 хонь

1 хонь - 1 хонь

1 ямаа - 0.9 хонь

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ-4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу-3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр-2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал.

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу-Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр-Өнгөрсөн жилийн төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бусын хорогдол болно.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 15-20

Азарга - 10-15

Бух - 25-30

Хуц, ухна - 50-67

Малын зүй бусын хорогдолд. өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон малын тоог, оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

Хадлан өвс -	0.45
Таримал тэжээл -	0.35
Даршны ургамал -	0.25
Гар тэжээл, хужир шүү -	1.0
Үр тарианы хаягдал -	0.9
Лай -	0.4
Сүрэл -	0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна
 1. Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл – Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай гэж хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжөөсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай гэж тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ юм.

Хураасан талбай гэж тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээ юм.

Га-гийн ургац гэж талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамлын тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тэр талбайн нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно.

Нийт ургац нь тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

ЭХЛЭЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, улс орны боловсруулах үйлдвэрийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагдаж байдаг.

Манай аймгийн эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар гол байр эзэлдэг.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн болон газар тариалангийн 2017 оны төлөв байдлыг нэгтгэн тусгав.

Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, энэ ч утгаараа мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу статистикийн хэлтэс мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг аймгийн хэмжээнд явуулж үр дүнг нэгтгэн гаргадаг.


Мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэсэн энэхүү судалгаа нь мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд суурь мэдээлэл нь болох юм.

I. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР

2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр манай аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 50.0 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж, 2017 оны жилийн эцэст нийт хөдөлмөрийн насны хүн амын 38.8 хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Зураг 1.

ДНБ-нд ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбар нь аймгийн ДНБ-ний 60.0-80.0 шахам хувийг эзэлсээр байсан ба 2000 оноос хойшхи хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшигаас үүдэн, мөн үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурах хандлагад шилжиж, улмаар үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, мөн мал аж ахуй болон газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй, баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болдог.

II. МАЛ АЖ АХУЙ

II.1 МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 205.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхтой харьцуулахад оны үнээр 4.2 хувиар өсөөд байна.

Хүснэгт 1.

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт


	2012	2013	2014	2015	2016	2017*	тэрбум төг	
							2017/2016	
							хувь	зөрүү
Тайлант оны үнээр	99.5	163.2	197.6	206.4	196.7	205.0	104.2	8.3

* -Урьдчилсан гүйцэтгэлээр

Мал аж ахуйн салбарт 2017 онд 73.7 мянган тн сүү, 1.1 мянган тн хонины ноос, 0.5 мянган тн ямааны ноолуур, 60.0 тн тэмээний ноос, 174.2 тн хөөвөр хялгас үйлдвэрлэв.

Зураг 2.

ХАА-н салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, бууралт



Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2017 оны тооцоонд малын ашиг шим, гарцын түүвэр судалгааны шинэчилсэн /2015 онд явагдсан судалгаа/ үр дүнг ашиглав.

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр

Бүтээгдэхүүний нэр төрөл	2013	2014	2015	2016	2017*	2017/2016	
						хувь	зөрүү
Сүү, мян.литр	37646.5	45688.2	53351.2	65251.3	73676.0	112.9	8424.7
Ингэний	338.5	408.3	400.3	328.2	600.2	182.9	272.1
Гүүний	5709.9	6801.3	8063.4	9584.1	11045.1	115.2	1461.1
Үнээний	19788.1	24751.5	30153.6	32361.6	23996.9	74.2**	-8364.8**
Хонины	5649.2	6685.1	7465.9	5555.4	10390.5	187.0	4835.1
Ямааны	6160.8	7042.0	7268.1	17422.0	27643.3	158.7	10221.3
Ноос, ноолуур, тн	1938.9	2271.5	2676.3	1535.4	1804.3	117.5	268.9
Тэмээний ноос	59.8	65.1	72.5	67.6	60.0	88.8	-7.6
Хонины ноос	1442.0	1695.4	2003.2	853.0	1112.8	130.5	259.8
Ямааны ноолуур	381.4	442.3	516.6	466.3	457.3	98.1	-9.0
Бодын хөөвөр	18.9	23.3	28.5	66.0	51.7	78.3	-14.3
Бодын хялгас	36.8	45.3	55.6	82.4	122.5	148.6	40.1

** - 2015 оны малын ашиг шим, гарцын түүвэр судалгааны үр дүнгээр үнээний сүүний гарц буурсан байна.

2017 онд аймгийн нэг хүнд дунджаар 641.8 л сүү ногдож байна. Нийт үйлдвэрлэсэн хэмжээг дотооддоо харьцуулснаар тооцсон ба сүүний үйлдвэрлэлийн хэмжээ 2017 онд буурсан шалтгаан нь малын ашиг шимийн бүтээгдэхүүний гарцын нормыг 2015 онд хийгдсэн малын ашиг шим, гарцын түүвэр судалгааны үр дүнгээр шинэчлэн тооцсонтой холбоотой. Өөрөөр хэлбэл үнээний сүүний гарц сүүлийн судалгааны үр дүнгээр манай аймагт буурсан байна.

Нэг хүнд ногдох мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн

	2013	2014	2015	2016	2017*
Сүү, л	359.7	496.4	579.8	702.8	641.8

Тайлбар: Өвөрхангай аймгийн 2016, 2017 оны хүн амын дундаж тоонд харьцуулав.

II.2 МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ХАШАА ХУДГИЙН 2017 ОНЫ ТООЛЛОГЫН ДҮН

Малтай өрх, малчдын тоо. 2017 онд мал бүхий 18956 өрх тоологдсон ба үүний 84.9 хувь нь буюу 16087 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Хувийн малтай өрх аймгийн хэмжээний нийт өрхийн 55.5 хувийг эзэлж байна.

2017 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 28265 малчид ажиллаж байна. Малчин өрхийн ам бүлийн тоо 57097 байгаа ба нэг малчин өрхийн ам бүлийн тоо дунджаар 3.5 байна. Малчдын 43.9 хувь нь буюу 12417 эмэгтэй малчид байна. Насны бүлгээр нь авч үзвэл 35.9 хувь нь 34 хүртэлх насны, 50.4 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 13.6 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.


Хүснэгт 4.

Өрх, малчдын тоо, насны бүтэц

	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
						хувь	зөрүү
Малтай өрх	17595	17925	17959	18520	18956	102.4	436
Малчин өрх	13570	14115	14658	15407	16087	104.4	680
Малчдын тоо	26254	27580	28446	29993	28265	94.2	-1728
Үүнээс:16-34 насны	10498	10720	10857	11087	10162	91.7	-925
35-аас тэтгэвэрт гарах насны	13055	13854	14594	15757	14252	90.4	-1505
Тэтгэврийн насны	2701	3006	2995	3149	3851	122.3	702
Нийт малчдаас эмэгтэй	12561	13073	13436	14083	12417	88.2	-1666
Насны бүтэц %							
Үүнээс:16-34 насны	39.3	38.9	38.2	37.0	36.0	-	-1.0
35-аас тэтгэвэрт гарах насны	48.9	50.2	51.3	52.5	50.4	-	-2.1
Тэтгэврийн насны	10.1	10.9	10.5	10.5	13.6	-	3.1
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	257	291	308	338	357	105.6	19.0

2017 онд малтай өрхийн тоо 2016 онтой харьцуулахад 436-аар, малчин өрх 680-аар өсч, малчдын тоо 1728-аар буурсан байна. 2017 онд 1 малчин өрхөд 357 толгой мал ногдож байгаа нь 2016 оныхоос 19 толгойгоор нэмэгдсэн байна.

Малчдын тоо, насны бүлгээр



Малчдын соёл, ахуйн үзүүлэлт. 2017 оны тооллогоор нийт малчин өрхийн 78.2 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 67.0 хувь нь телевизортой, 15.9 хувь нь радио хүлээн авагчтай, 98.9 хувь нь гар утастай, 30.9 хувь нь автомашинтай, 50.8 хувь нь мотоцикльтой, 0.3 хувь нь трактортой, 72.8 хувь нь малын хашаатай, 17.1 хувь нь худагтай байна.


Хүснэгт 5.

Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд

	Өрхийн тоо						Малчин өрхөд эзлэх хувь					
	2012	2013	2014	2015	2016	2017	2012	2013	2014	2015	2016	2017
Цахилгаантай	11894	11130	12734	12408	12737	12587	87.4	82.0	90.2	84.7	82.7	78.2
Телевизтэй	11253	9439	10848	10710	10685	10780	82.7	69.6	76.9	73.1	69.4	67.0
Автомашинтай	3412	3888	4887	4292	4178	4963	25.1	28.7	34.6	29.3	27.1	30.9
Мотоцикльтой	7645	7043	7737	7636	7365	8169	56.2	51.9	54.8	52.1	47.8	50.8
Трактортай	60	71	68	54	60	43	0.4	0.5	0.5	0.4	0.4	0.3

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт нарны зайн цахилгаан эх үүсгүүрийн хэрэглээ нэмэгдэж, тэр хэмжээгээр ахуй соёлын үзүүлэлтүүд өссөөр байна.

Малчин өрхийн соёл ахуйн зарим үзүүлэлтүүд



Малын тоо. 2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 5743.5 мянга болж, 2016 оныхоос 534.9 мянгаар буюу 10.3 хувиар өсчээ. Энэ онд аймгийн дүнгээр малын тоо нь 5 төрөл дээрээ өссөн дүнтэй гарсан байна. Малын тооны өсөлт, бууралтыг сумчилж 5 төрөл тус бүрээр харвал Өлзийт суманд 7 тэмээ, Хужирт суманд 3 тэмээ, Нарийнтээл суманд 3.1 мянган толгой ямаа, Уянга суманд 4.4 мянган толгой ямаагаар тус тус буурч бусад бүх суманд малын тоо толгой 5 төрөл дээрээ өссөн байна.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 28756 толгой, адуу 364015 толгой, үхэр 298244 толгой, хонь 2663296 толгой, ямаа 2389219 толгойд хүрч, 2016 оныхоос тэмээ 2.5 мянга, адуу 40.6 мянга, үхэр 38.3 мянга, хонь 284.8 мянга, ямаа 168.7 мянган толгойгоор тус тус өссөн үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 6.

Малын тоо, төрлөөр

	мян.толгой						2017/2016	
	2012	2013	2014	2015	2016	2017	хувь	зөрүү
	Бүгд	2970.7	3486.0	4111.5	4511.0	5208.6	5743.5	110.3
Тэмээ	18.1	19.7	21.9	23.1	26.3	28.8	109.5	2.5
Адуу	170.5	205.9	246.9	280.2	323.4	364.0	112.6	40.6
Үхэр	113.9	144.9	183.3	217.6	259.9	298.2	114.7	38.3
Хонь	1310.9	1541.3	1821.1	2021.8	2378.5	2663.3	112.0	284.8
Ямаа	1357.2	1574.2	1838.3	1968.3	2220.5	2389.2	107.6	168.7

2017 онд 1890.5 мянган толгой төл бойжуулсан нь өмнөх оноос 211.9 мянгаар буюу 12.6 хувиар өсч, том малын зүй бус хорогдол 8.5 мянга буюу 22.5 хувиар буурсан байна. 2017 онд 112807 сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 37.8 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо 2016 оноос 18.5 хувиар буюу 17.6 мянган толгойгоор өссөн байна.

Манай оронд цас их орж, хүйтрэн өвөлжилт хүндэрч, гурван жил дараалан зуд үүрэлсэн жилүүд хамгийн сүүлд 1999-2001 онд мөн 2009-2010 онд шилжих өвөл тохиолдсон байна.

Хүснэгт 7.


Зудны дараах жилийн малын тооны өсөлт, төрлөөр

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1999-2001 оны зудны жилийн дараах жилд						
2002	1 665.3	13.3	115.1	75.3	805.9	655.7
2003	1 918.8	13.9	123.8	83	881.7	816.4
2003/2002 %	115.2	104.5	107.6	110.2	109.4	124.5
Нийт өсөлтөд 5 төрлийн эзлэх хувь	100.0	0.2	3.4	3.0	29.9	63.4
2009-2010 оны зудны жилийн дараах жилд						
2010	2 010.5	14.7	113.8	76.2	896.6	909.2
2011	2 425.6	15.9	141.1	90.6	1 051.7	1 126.3
2011/2010 %	120.6	108.2	123.9	118.9	117.3	123.9
Нийт өсөлтөд 5 төрлийн эзлэх хувь	100.0	0.3	6.6	3.5	37.4	52.3

Зүй бусаар хорогдсон том малын тоо 1999-2001 онд 1158.5 мянган толгойд хүрч байсан бол 2009-2010 оны зудны жилд 1664.3 мянган толгой мал зүй бусаар хорогдсон. Зудны дараах жилийн малын тооны өсөлтийг хүснэгт 4-өөс харвал 2002-2003 онд 15.2 хувиар өсч байсан бол 2010-2011 онд 20.6 хувь өссөн үзүүлэлт гарсан байна. Нийт өсөлтөд 5 төрлийн малын эзлэх хувийг авч үзвэл 2002 онд нийт өсөлтийн 63.4 хувийг ямаан сүргийн өсөлт хангаж байсан бол 2011 онд 52.3 хувь болж 11.1 пунктээр буурч, хонин сүргийн өсөлт 29.9 хувь байснаа 37.4 хувь болж 7.5 пунктээр өссөн нь эерэг үзүүлэлт гарчээ. Энэ үзүүлэлт нь 2012 онд 42 хувь, 2013 онд 45 хувь, 2014 онд мөн 45.0 хувь, 2015 онд 50.2 болж өссөөр байгаа нь сайн үзүүлэлт байна. Хонин сүргийн тооны өсөлт 2011 оноос хойш ямаан сүргийн тооны өсөлтөөс байнга дээгүүр байгаа

ба 2015 оны байдлаар хонин сүргийн тоо ямаан сүргийн тооноос 53.5 мянгаар, 2016 онд 157.9 мянгаар, 2017 онд 274.1 мянгаар тус тус илүү байна.

Зураг 5.



2017 онд тэмээн сүргийн нийт сүрэгт эзлэх хувь урд оны түвшинд, адуун сүргийн эзлэх хувь 0.1 пункт, үхэр сүргийн нийт сүрэгт эзлэх хувь 0.4 пункт, хонин сүргийн нийт сүрэгт эзлэх хувь 1.6 пунктээр тус тус өсч, ямаан сүргийн эзлэх хувь 2 пунктээр буурсан байна.

Хүснэгт 8.

Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд, мян.толгой

	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
							хувь	зөрүү
Бойжуулсан төл	932.0	1137.2	1327.8	1440.6	1678.5	1890.5	112.6	212
Том малын зүй								
бусын хорогдол	8.0	19.7	8.9	64.6	37.8	29.3	77.5	-8.5
Хээлтэгч малын тоо	1190.5	1387.8	1630.0	1814.7	2092.9	2285.5	109.2	192.6
Хээл хаясан								
хээлтэгч	0.002	16.6	6.5	26.1	33.7	24.9	73.9	-8.8
Сувайрсан хээлтэгч	0.2	52.3	25.5	86.0	102.6	145.3	141.6	42.7

Нийт малын тоо хамгийн өндөр өсөлттэй нь Төгрөг сум 20.9 хувь, хамгийн бага өсөлттэй нь Нарийнтээл сум 0.3 хувийн өсөлттэй байна.

2001 оноос хойшхи жилүүдийн малын тооны өсөлт, бууралт

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	15	12	14	15	15	15
Буурсан жилийн тоо	2	5	3	2	2	2
2001 оноос өссөн хэмжээ, мян.тол	3874.4	14.1	223.0	198.9	1752.2	1686.2
2001 оноос буурсан хэмжээ, мян.тол	-	-	-	-	-	-

2001 оноос хойшхи 17 жилийн 15 жилд нь малын тоо өсч, 2 жилд нь буурчээ. Энэ хугацаанд малын тоо 2009 онд хамгийн өндөр буюу 3620.2 мянгад хүрч байсан ба 2015 онд энэ үзүүлэлт дээшилж 4511.0 мянга, 2016 онд 5208.6, 2017 онд 5743.5 мянгад хүрээд байна.

2017 оны байдлаар нийт мал сүргийн 88.0 хувийг бог мал, 12.0 хувийг бод мал эзэлж байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	100	100	100	100	100	100
Тэмээ	0.7	0.6	0.6	0.5	0.5	0.5
Адуу	5.8	5.7	5.9	6.0	6.2	6.3
Үхэр	3.7	3.8	4.2	4.5	4.8	5.2
Хонь	43.4	44.1	44.2	44.3	44.8	46.4
Ямаа	46.4	45.7	45.2	44.7	43.6	41.6


Бог малын дотор хонь 75 хувь, ямаа 25.0 хувь байсан уламжлалт харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээгээр алдагдсаар байгаа буюу жил ирэх тусам ямааны эзлэх хувь нэмэгдсээр байсан энэ харьцаа 2009 онд бага зэрэг буюу 1.4 хувиар буурсан үзүүлэлт гарч байсан. 2010 оны зудтай жилд ч өссөн үзүүлэлт гарсаар байсан байна. Нийт сүрэгт ямаан сүргийн эзлэх хувь 2008 оны эцэст 45.1 хувь байсан бол 2009 онд 43.8 хувь болж 1.3 пунктээр буурч, 2010 онд 45.2 хувь болж 1.4 пунктээр, 2011 онд 46.4 хувь болж 1.2 пунктээр өссөн харин 2012 онд 0.7 пунктээр буурсан, 2013 онд мөн 0.5 пунктээр, 2014 онд мөн 0.5 пунктээр буурч байсан ба 2015 онд бог малд хонин

сүргийн эзлэх хувь 50.7 хувь болсон байна. 2016 оны хувьд энэ үзүүлэлт нь 51.7 хувь болж, 2017 онд 52.7 хувьд хүрчээ.

Сумдаар авч үзэхэд бог малынх нь 34.0-74.2 хүртэлх хувийг ямаан сүрэг эзэлж байна. Хамгийн өндөр нь Богд суманд нийт бог малын 74.2 хувийг ямаан сүрэг эзэлж байгаа бол хамгийн бага нь Бүрд суманд нийт бог малын 34.0 хувийг ямаан сүрэг эзэлж байна. Ямаан сүргийн тоо толгойн өсөлт өндөр байх нь байгаль орчин, бэлчээрийн хүрэлцээнд ямар нөлөөтэйг тогтоож, сүргийн бүтцийн зохистой харьцааг тодорхойлж, энэ талаар мэргэжлийн байгууллагаас асуудал боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Зураг 6.


Нийт сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувь



2017 онд Өвөрхангай аймагт нийт мал болон тэмээ, ямаан сүргийн тоогоор Богд сум, адуун сүргийн тоогоор Хужирт сум, үхэр сүргийн тоогоор Уянга сум, хонин сүргийн тоогоор Баянгол сум тус тус тэргүүлж байна.

2017 оны эцэст тоологдсон малын дүнгээр Богд сум 454.7, Баян-Өндөр сум 426.1, Баянгол сум 412.1, Бүрд сум 364.4, Уянга сум 350.0 мянган толгой малаар тус тус тэргүүлж байна. Нийт 19 сумын 109 багаас малаараа Баянгол сумын Өнц баг 120.6, Бүрд сумын Ар жаргалант баг 106.9, Бат-Өлзий сумын Улаан-Ам баг 104.8, Баян-Өндөр сумын Батхаан баг 102.3, Баянгол сумын Цавын-Ихэр баг 97.1 мянган толгой малаар тус тус тэргүүлж байна.

Зураг 7.



Хувийн /амины/ малын тоо. 2017 онд хувийн малын тоо 5737.6 мянган толгой мал тоологдож, нийт малын 99.9 хувийг эзэлж байна. (Хавсралт 9.10)

Хувийн малын тоо 2016 оныхоос 534.3 мянгаар буюу 10.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 11.

Хувийн малтай өрх, малын тоо

Он	Малтай өрхийн тоо, мян.өрх	Бүгд	Үүнээс:					мян.тол
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2001	21.8	1854.2	14.7	140.5	99	900.3	699.7	
2002	20.6	1655.8	13.3	114.8	75.2	799	653.5	
2003	20.1	1910.8	13.9	123.6	82.9	876.5	813.9	
2004	19.9	2148.4	13.8	132.8	91.1	966.6	944.1	
2005	19.7	2294.3	13.1	136.4	99.6	1054.8	990.4	
2006	19.3	2616.2	13	151	111	1208.7	1132.5	
2007	20.0	3182.7	13.5	174.7	133.3	1457.1	1404.1	
2008	20.1	3443.1	14.1	172.8	134.7	1564.7	1556.8	
2009	19.9	3610.9	15.1	183.3	140.9	1684.5	1587.1	
2010	18.0	2008.4	14.7	113.7	76.2	895.0	908.8	
2011	17.2	2423.4	15.8	141.1	90.5	1 050.1	1 125.8	
2012	17.3	2967.9	18.1	170.5	113.9	1308.8	1356.5	
2013	17.6	3482.6	19.7	205.8	144.8	1538.6	1573.6	
2014	17.9	4102.6	21.9	246.6	182.7	1816.0	1835.4	
2015	18.0	4506.3	23.1	280.1	217.4	2018.4	1967.3	
2016	18.5	5203.3	26.2	323.3	259.7	2374.7	2219.4	
2017	18.9	5737.6	28.7	363.9	297.9	2659.0	2388.0	

2017 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 41.6 хувийг ямаа, 46.3 хувийг хонь, 6.3 хувийг адуу, 5.2 хувийг үхэр, 0.5 хувийг тэмээ эзэлж байна.

2017 оны эцэст байгаа иргэдийн хувийн малын бүлэглэлтээс авч үзвэл 2016 оныхоос 100 хүртлэх малтай өрхийн тоо 334-өөр, 101-200 толгой малтай өрхийн тоо 38-аар буурч, бусад бүлгийн буюу 201-с дээш толгой малтай бүлгийн өрхийн тоо бүх бүлэгт өссөн дүн гарчээ.

2017 онд нийт малтай өрхөд 100 хүртэл толгой малтай өрхийн эзлэх хувийн жин 26.2 хувь болж, 2016 оныхоос 2.4 пунктээр буурсан, 101-200 толгой малтай өрхийн нийт малтай өрхийн тоонд эзлэх хувийн жин 22.5 болж өмнөх оноос 0.8 пунктээр мөн буурсан, 201-ээс дээш малтай бүлгийн өрхийн эзлэх хувийн жин 51.3 хувь болж, өмнөх оноос 3.1 пунктээр өссөн байна. 2016 оны байдлаар малтай өрхийн 28.6 хувь нь 100 хүртэл толгой малтай, 23.3 хувь нь 101-200 толгой малтай байсан байна. Өөрөөр хэлбэл малтай нийт өрхийн 51.9 хувь нь 200 хүртэл толгой малтай өрх байсан байна.

Хүснэгт 12.

Малтай өрхийн малын бүлэглэлт

	Малтай өрхийн тоо			Малтай өрхөд ногдох мал			Малын тоо, мян.тол		
	2015	2016	2017	2015	2016	2017	2015	2016	2017
Бүгд	17959	18520	18956	251	281	303	4506.3	5203.3	5737.6
100 хүртэлх малтай	5726	5291	4957	49	50	52	283.4	266	258.7
101-200 малтай	4536	4311	4273	151	149	149	684.7	642	636.7
201-500 малтай	5455	6107	6475	313	316	320	1708.6	1929	2070.3
501-999 малтай	1622	2027	2310	654	667	673	1061.5	1352.7	1553.9
1000-1499 малтай	520	641	762	1138	1159	1155	591.5	742.7	879.9
1500-2000 малтай	68	101	122	1485	1687	1657	101	170.4	202.1
2001 дээш малтай	32	42	57	2363	2393	2386	75.6	100.5	136

1000 ба түүнээс дээш малтай 941 өрх тоологдсон байна. Бүрд суманд 108 өрх, Баян-Өндөр суманд 100 өрх, Баянгол суманд 104 өрх, Гучин-Ус суманд 67 өрх, Богд суманд 76 өрх тус бүр 1000 болон түүнээс дээш мал тоолуулсан ба дээрх 5 сум нь мянгат малчны тоогоор аймагтаа тэргүүлж байна.

Малтай 1 өрхөд дунджаар тэмээ 2, адуу 19, үхэр 16, хонь 140, ямаа 126 ноогдож байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо (толгойгоор) аймгийн 19 сумын хэмжээнд урд оноос өссөн үзүүлэлт гарсан ба 2017 онд Бүрд сум малтай нэг өрхөд ноогдох малын тоогоор тэргүүлж байна. Бүрд сумын малтай нэг өрхөд

500 толгой мал ноогдож байна. Энэ үзүүлэлт нь өмнөх онд 487 байсан ба 13 толгойгоор нэмэгдсэн байна.

Хүснэгт 13.

Малтай 1 өрхөд ногдох малын тоо, төрлөөр

	2015	2016	2017					
			Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
ДҮН	251	281	238	2	19	16	140	126
10 хүртэл малтай	7	7	8	-	1	4	1	2
11-30 малтай	21	22	29	-	1	4	7	10
31-50 малтай	41	41	46	-	2	4	15	20
51-100 малтай	75	74	81	-	4	7	29	35
101-200 малтай	148	149	157	-	10	12	62	65
201-500 малтай	313	316	264	1	21	17	138	143
501-999 малтай	654	667	460	4	41	28	321	280
1000-1499 малтай	1138	1159	776	10	72	47	619	406
1500-2000 малтай	1485	1687	936	21	112	54	944	552
2001 дээш малтай	2363	2393	1327	21	176	88	1387	714

Хээлтэгч мал. 2017 оны эцэст 2285.5 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь 2016 оныхоос 192.6 мянган толгойгоор өссөн дотор ингэ 1.0 мянгаар, гүү 12.7 мянга, үнээ 13.2 мянга, эм хонь 107.4 мянга, эм ямаа 58.3 мянган толгойгоор тус тус өссөн байна.


Хүснэгт 14.

Хээлтэгч малын тоо

	2012	2013	2014	2015	2016	2017	мян.тол	
							2017/2016	
							хувь	зөрүү
Бүгд	1190.5	1387.8	1630.0	1814.7	2092.9	2285.5	109.2	192.6
Ингэ	6.4	7.6	7.8	8.4	9.3	10.3	110.8	1
Гүү	49.4	59.8	71.3	82.2	96.7	109.4	113.1	12.7
Үнээ	41.9	51.8	64.5	75.9	91.0	104.3	114.6	13.3
Эм хонь	547.9	641.9	758.8	849.5	997.8	1105.2	110.8	107.4
Эм ямаа	544.9	627.4	727.6	798.8	898.1	956.4	106.5	58.3

Хээлтэгч мал нийт малын 39.8 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 35.8 хувь, адуун сүргийн 30.0 хувь, үхэр сүргийн 35.0 хувь, хонин сүргийн 41.5 хувь, ямаан сүргийн 40.0 хувийг тус тус эзэлж байна.

Өүүдөдэйгэеэ өйны өсөлт, бууралт



Хээлтэгч малын тооны өсөлт, бууралтыг сумдаар авч үзвэл Есөнзүйл суманд 5 ингэ, Хужирт суманд 1 ингэ, Бүрд суманд 158 гүү, Бүрд суманд 253 эм ямаа, Баруунбаян-Улаан суманд 96 эм ямаа, Нарийнтээл суманд 2542 эм ямаа, Уянга суманд 3000 эм ямаа тус тус буурч бусад сумдад 5 төрөл дээрээ өссөн дүн гарчээ.

Хүснэгт 15.


Төл бойжилт, мян.тол

	Бүгд			Үүнээс:				
	2015	2016	2017	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	1531.4	1710.4	1956.6	4.9	89.8	85.6	944.8	831.5
Бойжсон төл	1440.6	1678.5	1890.5	4.9	89.0	84.8	925.2	786.6
Бойжилтийн хувь	94.1	98.1	96.6	98.9	99.1	99.1	97.9	94.6

2017 онд гарсан төлийн 96.6 хувийг буюу 1890.5 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2016 оныхоос 211.9 мянган толгойгоор буюу 12.6 хувиар өссөн байна. Гарсан ботгоны 98.9 хувь, унаганы 99.1 хувь, тугалны 99.1 хувь, хурганы 97.9 хувь, ишигний 94.6 хувийг бойжуулсан байна.

Зураг 9.

Айяаооёёнаг өөёёг өй



Бойжуулсан төл 2016 оныхоос таван төрөл дээр өссөн үзүүлэлт гарсан байна.


Хүснэгт 16.

Бойжуулсан төл

	МЯН.ТОЛ					
	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	932.0	1137.2	1327.8	1440.6	1678.5	1890.5
Тэмээ	3.2	2.9	3.6	3.5	4.4	4.9
Адуу	37.6	45.1	53.7	63.7	73.3	89.0
Үхэр	31.3	39.1	48.9	59.6	69.5	84.8
Хонь	428.2	528.9	625.9	699.1	807.9	925.2
Ямаа	431.7	521.0	595.6	614.7	723.4	786.6

Зураг 10.

100 үйүүн айгээсөөний ө%



Хүснэгт 17.

100 эхээс бойжуулсан төл

	МЯН.ТОЛ					
	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	96.2	95.5	95.7	95.7	92.5	90.3
Тэмээ	56.7	46.6	48.4	50.5	52.5	53.0
Адуу	89.5	91.4	89.9	89.9	89.1	92.0
Үхэр	90.5	93.3	94.7	94.7	91.6	93.2
Хонь	97.7	96.5	97.5	97.5	95.1	92.7
Ямаа	96.3	95.6	94.9	94.9	90.6	87.6

Том малын зүй бус хорогдол. 2017 онд оны эхний малын 0.6 хувьтай тэнцэх 29.3 мянган толгой мал хорогдсон байна. Мал өвөлжилт, хаваржилт 2009-2010 онд өмнөх жилүүдээс хүндэрч, 1664.3 мянган толгой том мал зүй бусаар хорогдоод байсан бол 2011 онд эрс буурч, 2012 онд 2011 оноос 3 дахин буурчээ. 2013 онд харин 2012 оноос 1.4 дахин буюу 11655 толгойгоор өссөн байна. 2014 онд өмнөх оноос 1 дахин буурч 8.9 мянган толгой мал хорогдсон байна. 2015 онд 64.6 мянга, 2016 онд 37.8 мянга, 2017 онд 29.3 мянган толгой

мал хорогджээ. 2017 онд нийт хорогдсон малын 56.7 хувийг ямаа, 37.3 хувийг хонь, 2.9 хувийг адуу, 2.9 хувийг үхэр, 0.2 хувийг тэмээний хорогдол эзэлж байна.

Хүснэгт 18.


Том малын зүй бусын хорогдол

	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	8.1	19.7	8.9	64.6	37.8	29.3
Тэмээ	0.02	0.02	0.03	0.2	0.02	0.05
Адуу	0.4	0.8	0.4	2.8	2.0	0.8
Үхэр	1.3	0.8	0.3	1.5	1.6	0.9
Хонь	2.7	8.2	3.4	25.5	15.3	10.9
Ямаа	3.7	9.9	4.6	34.6	18.9	16.6

Том малын хорогдол Гучин-Ус суманд хамгийн өндөр буюу буюу 4.7 мянган толгой мал, Бүрд, Баруунбаян-Улаан, Өлзийт, Богд, Нарийнтээл, Тарагт, Уянга, Хайрхандулаан, Хужирт, Хархорин сумдад 1.1-3.4 мянган толгой мал хорогдсон нь нийт аймгийн хэмжээний том малын хорогдлын 93.8 хувийг эзэлж байна. Бусад сумдын хорогдол 1.0 мянгаас доош толгой буюу 6.2 хувийг эзэлж байна.

Зураг 11.

Ойи лэеүй ççé áóñuí òìðíääëë



Хүснэгт 19.

Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	0.2	0.6	0.2	1.4	0.8	0.6
Тэмээ	0.1	0.1	0.1	0.8	0.1	0.2
Адуу	0.3	0.4	0.2	1.0	0.7	0.3
Үхэр	1.4	0.6	0.2	0.7	0.7	0.3
Хонь	0.3	0.5	0.2	1.3	0.8	0.5
Ямаа	0.3	0.6	0.3	1.8	1.0	0.7

2017 онд нийт хорогдлын 43.9 хувь буюу 12866 толгой мал гэнэтийн аюулаар, 8.3 хувь буюу 2440 толгой нь өвчнөөр, 52.2 хувь буюу 14.0 мянган толгой нь бусад шалтгаанаар хорогджээ.

Хүснэгт 20.

Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо

	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	956	3660	820	7796	4974	12866
Тэмээ	-	-	-	14	7	15
Адуу	30	16	27	510	292	240
Үхэр	9	29	22	201	177	365
Хонь	466	1614	410	3980	2057	5108
Ямаа	451	2001	361	3091	2441	7138

Малын хээл хаялт, сувайралт. 2017 онд оны эхний хээлтэгч малын 1.1 хувьтай тэнцэх 24.9 мянган мал хээл хаяж, 6.3 хувьтай тэнцэх 144.5 мянган мал сувайрсан байна. Хээл хаясан хээлтэгч малын тоо 2016 онхоос 8.8 мянган толгойгоор буурч, сувайрсан хээлтэгч малын тоо 41.9 мянган толгойгоор өсчээ.

Хүснэгт 21.

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо

	Сувайрсан						Хээл хаясан					
	2012	2013	2014	2015	2016	2017	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	42.8	52.3	55.8	86.0	102.6	144.5	8.2	16.6	11.8	26.1	33.7	24.9
Ингэ	0.2	0.06	0.1	0.08	0.05	0.08	0.02	0.003	0.005	0.005	0.005	0.04
Гүү	3.7	4.2	4.9	6	9.1	9.0	0.5	0.7	0.6	0.6	1.5	0.9
Үнээ	2.9	3.2	3.8	4	6.6	7.5	0.3	0.7	0.5	1.2	1.0	0.7
Эм хонь	17.0	22.5	21.5	33.3	38.9	63.1	2.3	5.4	4.2	6.7	8.0	6.9
Эм ямаа	16.1	22.2	25.5	42.5	47.9	64.7	5.2	9.8	6.5	17.6	23.2	16.4


Хүснэгт 22.

Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь

	Хээл хаясан						Сувайрсан					
	2012	2013	2014	2015	2016	2017	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	4.4	1.4	3.4	1.6	1.9	1.1	0.9	4.4	0.7	5.3	5.7	6.3
Ингэ	2.9	0.05	1.7	0.1	0.1	0.4	0.3	0.9	0.1	1.1	0.5	0.7
Гүү	8.8	1.4	7.0	0.9	1.9	0.9	1.1	8.5	0.8	8.4	11.1	8.3
Үнээ	8.4	1.6	5.9	1.9	1.3	0.6	0.9	7.7	0.8	6.3	8.7	7.2
Эм хонь	3.9	1.0	2.8	0.9	0.9	0.6	0.5	4.1	0.6	4.4	4.6	5.7
Эм ямаа	4.3	1.8	3.5	2.4	2.9	1.7	1.2	4.1	0.9	5.8	6	6.8

Аймгийн хэмжээнд төл өгөөгүй хээлтэгч малын тоо өмнөх оноос 33.5 мянгаар өссөн байна.

Зураг 12.



Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. 2017 онд 41.3 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2016 оныхоос 2.3 мянган толгойгоор буюу 5.9 хувиар өссөн байна. 2016 оныхоос буур 11, бух 95, азарга 1101, хуц 814, ухна 269 толгойгоор тус тус өсчээ.

Хүснэгт 23.

Хээлтүүлэгч малын тоо

МЯН.ТОЛ

	Хээлтүүлэгч мал						Үүнээс: шинээр тавьсан					
	2012	2013	2014	2015	2016	2017	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	25991	29286	33125	35146	38988	41281	20	91	37	39	24	32
Буур	230	238	239	251	290	301	1	-	-	1	1	-
Азарга	6477	7272	8340	9077	10346	11447	13	38	20	24	24	22
Бух	1733	2157	2612	2896	3517	3612	1	16	6	4	4	8
Хуц	8798	9968	11178	11936	13259	14073	4	28	6	7	7	1
Ухна	8753	9651	10756	10986	11579	11848	1	9	5	3	3	1

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 50-67 хээлтэгч ногдох ёстой ба 2017 онд аймгийн дунджаар 78 эм хонь, 81 эм ямаа ногдож үржлийн нормоос бага зэрэг дээгүүр, бод малын хувьд ингэ 34 байгаа нь үржлийн нормоос 14-өөр дээгүүр, гүү, үнээний хувьд үржлийн нормын түвшинд байна.

Хүснэгт 24.

Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо

МЯН.ТОЛ

	Үржлийн норм	2012	2013	2014	2015	2016	2017
Ингэ	15-20	28	30	33	33	32	34
Гүү	10-15	8	8	9	10	9	10
Үнээ	25-30	24	24	25	26	26	29
Эм хонь	50-67	62	64	68	71	75	78
Эм ямаа	50-67	62	65	68	73	78	81

Малын хэрэглээний зарлага. 2017 онд оны эхний нийт малын 25.5 хувьтай тэнцэх 1326.2 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2016 оныхоос 383.1 мянган толгойгоор буюу 40.6 хувиар өссөн байна. Хэрэглээнд зарцуулсан малын тоо 5 төрөл дээр өссөн үзүүлэлт гарсан байна.

Малтай нэг өрх дунджаар 70 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан байна. Үүнийг аймгийн хэмжээний нийт өрхөөр тооцвол нэг өрхөд дунджаар 39 толгой мал хэрэглээндээ зарцуулсан байна. Энэ үзүүлэлт нь урд оноос 14 толгойгоор нэмэгдсэн байна.


Хүснэгт 25.

Малын хэрэглээний зарлага

	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	378.9	602.2	693.4	976.5	943.1	1326.2
Тэмээ	1.0	1.3	1.4	2.2	1.2	2.4
Адуу	7.8	8.9	12.3	27.6	28.1	47.5
Үхэр	6.6	7.4	10.1	23.8	25.6	45.7
Хонь	166.3	290.3	342.8	472.8	435.9	629.4
Ямаа	197.2	294.1	326.8	450.1	452.3	601.2
	Оны эхний малд эзлэх хувь					
Бүгд	15.6	20.3	19.9	23.8	20.9	25.5
